

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

№ 01

Тариалан сум

**Компанийн жилийн үйл ажиллагааны  
болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан  
дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76.1.11 дэх заалт, “Хөвсгөл алтан дуулга” хувьцаат компанийн дүрмийн 7.8.3 дахь заалтыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:


1. “Хөвсгөл алтан дуулга” хувьцаат компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

2. Тус компанийн 2022 оны үйл ажиллагааг “хангалттай” гэж дүгнэхийн зэрэгцээ Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтэд гарсан санал, өгөгдсөн үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Компанийн удирдлагуудад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ДУЛАМСҮРЭН



## КОМПАНИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТ

### Агуулга:

I. Үндсэн зорилтын хэрэгжилт: Тариалалтын, Үйлдвэрлэлийн технологийн, Органик газар тариалан эхлүүлэх, баталгаажуулахтай холбоотой ажлууд, үйлдвэрлэлийн менементийг сайжруулах, тоног төхөөрөмжийн шинэчилэл, засвар үйлчилгээ хийх, чанарын баталгаажуулалтын ажлын үр дүнгийн тайлагнал тодорхой, ойлгомжтой болжээ.


II. Компанийн үйл ажиллагаатай холбоотой гол ажлуудаас: ... Компанийн засаглал, кодекстэй холбоотой горимын ажлууд нэн чухал байгааг 2023 онд анхаарч, холбогдох ажлыг хийж дуусгах нь тулгамдсан асуудал байх юм байна.

**2022 онд:** - Газар тариалан, гурилын үйлдвэрлэлийн технологийн үйл явц, тогтвортой тасралтгүй үйл ажиллагааны горимыг бий болгох суурь ажлуудыг эхлүүлсэн жил болсон байна.

- Үйл ажиллагааны тоон үзүүлэлтийг Зураг 01, 02-т зэрэгцүүлэв.

### 2016-2022 оны үзүүлэлт:

Зураг 01



Зураг 02



2022 оны зорилтуудаас: "... органик газар тариаланг эхлүүлэх баталгаажуулах ажил, тариалангийн талбайн хамгаалалт, техник технологийн шинэчлэлтэй холбоотой ажлуудыг амжилттай хэрэгжүүлж, эхлүүлсэн байна.

Ач холбогдол өгөх ЧУХАЛ АСУУДАЛ: Сүүлийн жилүүдэд "байгаль цаг уур, үрийн нөөцийн чанар, хүрэлцээ, хангалт, боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн нөөц, үнийн хэлбэлзэл .. зэрэг хүчин зүйлийн шууд нөлөөллөөс хамааралтайгаар ногдол ашиг хувиаралсангүй.

Олон жил үргэлжилж, цаашид ч байсаар байх энэ сөрөг, эерэг нөлөөллийг давж гарах "ШИНЭ САНАА, ШИЙДЭЛ ГАРГАЛГАА"-г судалгаа тооцоо, шийдлийн төсөлтэйгээр ойрын хугацаанд танилцуулахыг Хороод, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдэд үүрэг болгож байна.

Газар тариалан, гурилын үйлдвэрлэлийг тусгаарласан нь менежментийн чухал шийдвэр болсон хэдий ч асуудлыг бүрэн шийдэх шийдэл болж чадахгүй байгааг, өнгөрсөн санхүүгийн жилд ойлгож авлаа. Хөрөнгө оруулалт санхүүжилт татах зорилгоор банк санхүү, төрийн болон төслийн байгууллагуудад хандахад "харилцан хамаарал"-ын асуудал хэвээр байна.

Иймд эдгээр тулгамдсан асуудлыг давах шинэлэг, оновчтой шийдэл маш чухал байгаа тул: олон талт хүчин зүйлийг тооцоолсон санаа шийдлийг ТАНИЛЦУУЛГА-даа заавал багтаасан байхыг дашрамд онцлон үүрэг болгов.

Тулгуур 2 багана "гурилын үйлдвэрлэл, газар тариалан"-гаа дэмжих, дагалдуулан хөгжүүлэх чиглэлийг тасралтгүйгээр өргөжүүлж, технологийн дэвшил, боломжит нөөцөөрөө удирдан зохицуулж, хэрэглэгч, харилцагчдын сэтгэл ханамжийн хүлээлтийг хангасан эерэг ажлуудыг хийсэн зэрэг хүчин зүйлийн нөлөөлөл 2022 онд хангалттай сайн байна.

Давагдашгүй хүчин зүйл газар тариалангийн салбарт хэзээд байх тул энэ бүхнийг тогтвортойгоор давах технологийн шийдэл, шинэлэг санаа, хөрөнгө оруулалт 2023-2024 онд чухал асуудлын нэг хэвээр байх нь.

Мөн Хөрөнгийн биржийн үнэ цэнэтэй эрэмбээ баталгаажуулан хадгалах бодлого тун чухал байна.

2022 оны ажлын үр дүнг: а) Үйл ажиллагааны зорилтын хэрэгжилт  
б) Төлөвлөгөөт зорилт гэсэн 2 чиглэлээр дүгнэсэн.

Үйл ажиллагааны зорилт: Чанарын үзүүлэлтийг гүйцэтгэх удирдлагын тайлан, газар дээр хийж хэрэгжүүлсэн ажлууд, технологийн, лабораторийн орчин, ХАБ, ажлын орчин нөхцөл сайжруулах чиглэлээр байгаа нөөц төсвийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн. 98 хувь

Төлөвлөгөөт зорилт: Тоон үзүүлэлтийн биелэлтийг гүйцэтгэх удирдлагын тайлан, төлөвлөгөөт зорилтын хэрэгжилт, бодит нөхцөл байдал зэрэг шууд хамаарах ажлыг үнэлж, 75 хувь.

2022 оны ажлыг эдгээр гол үзүүлэлтийг нэгтгэн дүгнэв.

**2023 онд:** компанийн бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр нарийн тооцоо, судалгаа гарган, үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх, компанийн **үнэ цэнийг өсгөх чиглэлээр үр дүн гаргах шаардлагатайг онцлон тэмдэглэв.**

2022 онд компанийн үйл ажиллагааг Тоон үзүүлэлтийн хувьд: "Хангалттай". Үндэслэл: ГҮ-ийн өртөг нэмэгдсэн, Хуримтлагдсан өрийг барагдуулсан, нэгж бүтээгдхүүний өртөг өссөн хэдий ч зах зээлд борлуулах бүтээгдхүүнийхээ үнийг нэмээгүй зэрэг нөлөөллөөс хамааран АШИГ-гүй ажилласан. Баруун бүсэд ургац алдсанаас үүдэлтэй "буудайн стандарт" чанар хангах чадвар муу гэх мэт онцгой нөхцөл байдлаас хамааран бүтээгдхүүний гарц буурсан" гэж дүгнэв.  
Тоон бус үзүүлэлтийн хувьд: "Хангалттай сайн".

Нэгдсэн дүгнэлт: "Үйл ажиллагааг хангалттай" гэж дүгнэв.



**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 дүгээр сарын 28 -ны өдөр

№ 02

Тариалан сум

**Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны  
зардлын төсвийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62.1.12, 65.6.6 дахь заалтыг үндэслэн “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1.Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын төсвийг 89,990,000 төгрөгөөр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ДУЛАМСҮРЭН

ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА  
ХУВЬЦААТ КОМПАНИ

Хувьцаа эзэмшигчдийн Хурлын 2023 оны 22-р тогтоолын хавсралт

УДИРДАХ  
ЗӨВЛӨЛ

Хөвсгөл Алтандуулга ХК-ийн I-ийн ТУЗ-ийн 2023 оны зардлын төсөв

д/д	Зардлын төсөв	Сарын зардал		Сар	Нийт зардал /төг
1	ТУЗ-ийн дарга	2,500,000		12	30,000,000
	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	630,000	1	12	7,560,000
	ТУЗ-ийн гишүүдийн цалин, нэмэгдэл : Энгийн гишүүд	50,000	6	12	3,600,000
	Хараат бус гишүүд	70,000	3	12	2,520,000
	Хороодын даргын нэмэгдэл	30,000	3	12	1,080,000
	ТУЗ-ийн даргын нэмэгдэл	30,000	1	12	360,000
		<b>3,310,000</b>			<b>45,120,000</b>
2	НДШ	446,850			6,100,000
		<b>3,756,850</b>			<b>51,220,000</b>
3	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, хороодын хуралд оролцсон байдлыг харгалзан олгох нэмэгдэл	50,000			5,850,000
4	Шуудан холбооны зардал	110,000		12	1,320,000
5	Бичиг хэргийн зардал	100,000		4	400,000
6	Шатахууны зардал	800,000	2	12	19,200,000
7	Зар сурталчилгаа	600,000		1	600,000
8	Хурлын зардал	1,200,000		2	2,400,000
9	Ажлын албаны болон бусад	750,000		12	9,000,000
	<b>Дүн</b>	<b>7,366,850</b>			<b>89,990,000</b>

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

№ 03

Тариалан сум

**ТУЗ-ийн гишүүдийн цалин  
урамшууллын тухай**

Компанийн тухай хуулийн 62.1.13 дахь заалт, “Хөвсгөл алтан дуулга” Хувьцаат Компанийн дүрмийн 7.8.7, 7.44-д заасныг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2023 оны цалин, урамшуулал, нэмэгдэл болон Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, хороодын хуралд оролцсон оролцооны нэмэгдлийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай” 04 дүгээр тогтоолын дагуу олгож байхаар тогтсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тогтмол цалин, урамшуулал, нэмэгдлийг жилийн эцэст, оролцооны нэмэгдлийг тухай бүр олгож байхыг ерөнхий нягтлан бодогч Ж.Отгоннямд зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Д.ДУЛАМСҮРЭН